



Ноён Жан Себастиен Жак танаа, \Jean Sebastien Jacques\
Гүйцэтгэх Ерөнхий захирал,
Rio Tinto Group
6 St James Square
London SW1 4AD

2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Эрхэм ноён Жан Себастиен Жак танаа,

Rio Tinto-гийн Лондонд болсон 2020 оны жилийн ерөнхий хурал (ЖЕХ)-ын талаарх Нээлттэй захидал

Энэ жилийн ерөнхий хурлаар Рио Тинто ХК-ийн хувьцаа эзэмшигчид ба итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн тавьсан асуултад өгсөн хариултын талаарх гомдлыг энэхүү нээлттэй захидлаар албажуулан тавьж байна.

Аудиогоор холбох шинэ формат нь компани болон хувьцаа эзэмшигчидэд шинэ тутам байсныг хүлээн зөвшөөрч байна. Гэвч дуу чимээний чанар ба Рио Тинтогийн уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг дор хаяж хоёр орноос шууд холбогдож орох боломж бүрдүүлээгүй нь олон тэрбум долларын корпораци уулзалтыг өндөр чанарын дижитал холболтоор хангаагүй нь бухимдалд нэмэрлэж байв.1

Виртуал холболтын доголдлын хажуугаар имэйлээр урьдчилан хүргүүлсэн болон шууд холболтоор тавьсан тодорхой асуултаудад өгсөн хариултауд нь энэ захидалд гарын үсэг зурсан хүмүүсийн хувьд бүрэн, нээлттэй, хангалттай байхаас ихээхэн хол байсныг тэмдэглэж байна. Тэдгээр нь дараах хүмүүс болно. Үүнд:

1. Сербийн Ложница нутгийг төлөөлсөн Зой Лужич (Zoe Lujic), Earth Thrive
2. Австралийн Хүний эрхийн Төвийн Кэрен Адамз(Keren Adams)
3. Publish What You Pay Madagascar (PWYPM)-ын Эрик Рандриандрасана (Eryck Randrianandrasana)
4. The Andrew Lees Trust (ALT)-ын Ивон Оренго (Yvonne Orenge)
6. Arizona Mining Reform Coalition (AMRC) –ны Рожер Федэрстоун (Roger Featherstone)
7. London Mining Network-ийн Эндрю Хикман (Andrew Hickman)
8. ОууТолгой Watch (Ханбогд сумын малчдыг төлөөлж)-ийн Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл
9. Нидерландын ТББ “SOMO”-ийн Родантэ Аалерс (Rhodante Ahlers)

Бидний тавьсан асуултууд нь Рио Тинтогийн Баруун Папуа дахь Grasberg, Боугэйнвиль дэх Panguna, Мадагаскар дахь QMM, Монголд Оюу Толгой, АНУ-ын Аризона дахь Resolution Copper, Серби дахь Jadar lithium зэрэг уурхайтай холбоотой хүрээлэн буй орчны бохирдол, компанийн засаглал ба ил тод байдлын талаар хэд хэдэн сэдвийг хамарсан юм.

Их Британийн компанийн хууль тогтоомжийн дагуу Рио Тинто өөрийн болон охин компаниудынхаа өмч хөрөнгийн байдлын талаар тайлагнах үүрэгтэй. Жилийн ерөнхий хуралдаанаар ТУЗ-өөс нь асуусан асуулт, мөн зохих тодруулга хүссэнд бүрэн хариулт авч чадаагүй тул бид Рио Тинто компанид албан ёсоор хандаж тавьсан асуулт бүрт хариуг, холбогдох компанийн амлалт мэдэгдэл бүрийг өгөгдөл, баримт, нотолгооны хамт бичгээр өгөхийг албан ёсоор хүсч байна. Асуултуудыг бүрэн эхээр нь, мөн өнөөг хүртэл Рио Тинто нь хэрхэн хариулж чадаагүйн тайлбарын хамт хавсаргасан болно.

Бид хариултыг 21 хоногийн дотор өгөхийг хүсч байна.

Хүндэтгэсэн,

Сербийн Ложница нутгийг төлөөлж Earth Thrive-ын Зой Лужич,
Австралийн Хүний эрхийн Төвийн Кэрен Адамз
Publish What You Pay Madagascar-ын Эрик Рандриандрасана
The Andrew Lees Trust (ALT)-ын Ивон Оренго
Arizona Mining Reform Coalition-ны Рожер Федэрстоун
London Mining Network-ийн Эндрю Хикман
Ханбогд сумын малчдыг төлөөлж ОюуТолгой Watch-ийн Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл
Нидерландын ТББ "SOMO"-ийн Родантэ Аалерс

Хувийг: Ноён Саймон Томпсон (Simon Thompson)-д, Rio Tinto, ТУЗ-ын дарга.

¹ Мадагаскараас Их Британийн дугаараар залгахад 10-15 минут тутамд шугам тасарч байсан нь нэг оролцогчийг хассан гэсэн үг юм. Холболт зохион байгуулагч нь шугам дээр нэг ч хүн алга гэж худал зарлаж бусдад асуулт тавих боломжийг хааж байсан.



Arizona Mining Reform Coalition-оос Рио Тинтогийн ЖЕХ-нд тавих асуултууд

Би Аризонагийн Таксон хотын иргэн Рожер Федэрстон ба би Arizona Mining Reform Coalition-ны захирал юм. Өнөөдөр Лондонд танай уулзалтанд оролцох боломжгүй байгаадаа харамсаж байна. Энэ бүхэн өнөөгийн ертөнцөд юу ч баталгаагүй, юүнд ч бүрэн найдаж болохгүйг харуулж байна.

Энэхүү боломжийг ашиглан Аризонагийн Финикс хотоос зүүн зүгт байрлах, Oak Flat гэгч уугуул иргэдийн ариун шүтээний болон экологи, амралтын хүрээлэн нутаглах олон мянган акр газрыг устгах шийдэл бүхий блокчлон олборлох технологит зэсийн Resolution Copper уурхайн төслийн талаар асуулт тавих завшаанд талархаж байна.

Өнгөрсөн 8-р сард АНУ-ын Ойн алба нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын урьдчилсан мэдэгдэл (БОНБУМ) гаргасан бөгөөд, тэр нь бүрэн бус байгаа ч, анхны ажиглалтаар Resolution Copper зэсийн уурхайн төсөл нь Oak Flat-ыг устгаж, 16,000 орчим акр газар ба 200,000 хүн амтай хотын хэрэглээтэй тэнцэх усыг ашиглах юм билээ.

Жан-Себастьян (ЖС) та надтай Рио Тинто компанийн гүйцэтгэх захирал албан ёсоор болохоосоо өмнө уулзахдаа Resolution Copper төсөл хэрэгжих боломжгүй гэх ойлголттой болмогц Рио Тинто төслийг үргэлжлүүлэхгүй гэж надад хэлсэн.

Гэвч БОНБУМ-д уг төслийн усны хэрэглээний хэмжээ нь "гүний усны тооцоолсон боломжит нөөцийн хэмжээнээс их байж мэднэ" гэсээр байна.

Өнгөрсөн жил Рио Тинтогийн ЖЕХ дээр та Рио Тинто нь Resolution Copper төслийг аливаа орон нутгийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх буюу илүү сайн тохируулах байдлаар хэрэгжүүлэх болно гэж мэдэгдсэн боловч та дэлхийн хаана ч байдаг хаягдлын далангийн аюулгүй байдлын хуулийг дагаж, илүү сайн хийх тухай хэлж бага зэрэг араа баталгаажуулсан шинжтэй.

БОНБУМ нь хаягдлын далангийн цэгийн 4 хувилбарын аль аль нь, мөн сонговол зохих хувилбар цэгийн байршлыг Бразил, Эквадор, Хятад зэрэг улсуудад хууль бус гэж үзэхгүйг тогтоосон байна. Гэвч 4 хувилбар ба сонговол зохих хувилбар нь ч манай Аризона мужийн Байгаль орчны чанарын албанаас тогтоосон хаягдлын далангийн аюулгүй байдлын сулхан стандартад нийцэхгүй байдаг.

Resolution Copper төсөлтэй дэлхийд ижилсэх ганц блокчлон цөмлөх технологит Оюу Толгой дахь төслийг хэрэгжүүлэх явцад үргэлжлэн тулгарч буй бэрхшээлүүд нь ба БОНБУМ-д тусгагдсан олон хүндхэн асуудлууд нь танай төсөл амжилтанд хүрэхгүй туршилт болно гэдгийг харуулаад байна.

Та нар бүтэлгүйтэж буй туршилтаас татгалзаж, эзэмшсэн бүх газар нутаг, уул уурхайн эрхээ буцааж, Oak Flat-тай холбоотой аливаа нэхэмжлэлээс татгалзах цаг болжээ.

Resolution Copper төслөө бүр мөсөн зогсоож, түүнтэй холбоотойгоор зайлшгүй ирэх шившиг, санхүүгийн алдагдлаас хувьцаа эзэмшигчдийгээ ангижруулах уу?

Рио Тинтогийн хариуд өгөх бидний тайлбар:

Рио Тинтогийн хариуг сонсоход хэцүүхэн байсны сацуу засч залруулах шаардлагатай хэд хэдэн зүйл байна. Рожер Федэрстоун өөрөө асуултаа асуухгүй Рио Тинтогийн талаас уншуулж, харин хариу авсныхаа дараа шаардлагатай бол тодруулга хийх нөхцлийг тохирсон юм.

Рио Тинто энэ тохиролцоогоо зөрчиж, ноён Федэрстоунд тайлбар тодруулгыг зөвшөөрөөгүй.

ЖС нь залруулах шаардлагатай хэд хэдэн зүйл хэлсэн. Энэхүү санал болгож буй төслийн талаар ЖЕХ-ынхаа үеэр Рио Тинто компани нь хувьцаа эзэмшигчиддээ буруу ташаа мэдээлэл өгч байгаа нь харамсалтай.

- x ЖС ЖЕХ дээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын эцсийн мэдэгдэл (БОНБЭМ)-ийг “удахгүй” гаргана гэж хэлсэн, гэвч төслийн саналыг хянаж буй АНУ-ын Ойн алба нь 2021 оны 12-р сараас өмнө гаргахгүй гэж ЖЕХ эхлэхээс хэд хоногийн өмнө мэдэгдсэн нь “удахгүй” гэдэгт ойртохгүй л байгаа юм.
- x Төсөлд өртөх бидний яриад байгаа 16000 акр талбайн тоо нь шууд АНУ-ын Ойн албаны БОНБУМ-ээс авсан тоо. Төсөл нь тэр их газрыг бараг ашиглахгүй гэж ЖС мэдэгдээд байдаг. Хэрэв Рио Тинтод бага акр талбайг ашиглах төслийн зураглалыг өөрчилсөн шинэ санал байгаа бол тэр нь олон нийтэд мэдээлэгдээгүй ба энэ захидлын хариуд Ойн алба ба Рио Тинто төслийн шинэ зураглалыг нийтэд ил болгох хэрэгтэй.
- x Санал болгож буй төсөлд ихээхэн хэмжээний “сэргээгдэх эрчим хүч” -ийг ашиглах болно гэж ЖС мэдэгдэв. Энэ нь бидэнд, олон нийтэд ба АНУ-ын Ойн албанд ч шинэ сонсогдож байгаа юм. Харин Рио Тинтогийн энэ төслийг эрчим хүчээр хангах эрх авсан Salt River Project компани нь АНУ-ын Ойн албанаас хурай овоолго дээрээ нарны цахилгаан станц барих зөвшөөрөл авсан ойролцоох уурхайгаас цахилгаан худалдан авах гэрээ байгуулахаас татгалзсан мэдээ байна. Дахин хэлэхэд хэрэв Рио Тинто төслийн дизайндаа өөрчлөлт хийж байгаа бол түүнийг олон нийтэд болон АНУ-ын Ойн албанд мэдэгдэж байх хэрэгтэй.
- x Эцэст нь, бидний сонссон зүйлээс дүгнэхэд няцаах өөр хэдэн зүйл байгаа ба “тийм” эсвэл “үгүй” гэх хариулт хүссэн “Resolution Copper төслөө бүр мөсөн зогсоож, түүнтэй холбоотойгоор зайлшгүй ирэх шившиг, санхүүгийн алдагдлаас хувьцаа эзэмшигчдийгээ ангижруулах уу?” гэсэн асуултанд огт хариу өгч чадаагүй байгаа.



Мадагаскарын QMM –ын тухай асуултууд ба RIO TINTO-гийн хариултын тухайд

1. Эрик Рандриандрасана (PWYPM)

Өнгөрсөн жилийн хурлаар Рио Тинто компани өөрийн QMM уурхай нь байгаль орчны хамгаалалтын хязгаар бүсийг зөрчиж, зэргэлдээ нуурын ёроолыг өртөгдүүлсэн гэж хүлээн зөвшөөрсөн. Энэ нь “алдаа” болсон гэж мэдэгдсэн. Рио Тинто нь хувь нийлүүлэгчид болон олон нийтэд QMM-ийн алдааны үр нөлөөг “өчүүхэн” гэж мэдэгджээ. Үүндээ Малагасийн төрийн зохицуулагчийн шинжилгээг иш татав. Зохицуулагч энэ шинжилгээний хариунд хэрхэн хүрсэн талаар нотлох баримтуудыг бид удаа дараа нэхэв. Нутгийн иргэд загасчлаж, ундныхаа усыг уурхайн эргэн тойронд байрлах нуур, голын уснаас авдаг тул алдааны улмаас QMM-ын боловсруулалтаар гарч буй бодисууд усыг бохирдуулж буй сураг ноцтой асуудал үүсгэж байгаа юм.

Рио Тинто нь бидний Мадагаскар дахь байгаль орчны улсын зохицуулагч ба QMM-д тавьсан асуулгаар уул асуудлын мөрөөр зохицуулагч ямар нэгэн техникийн судалгаа хийж байсан гэсэн нотолгоо гаргаж чадаагүй гэдгийг мэднэ. Өнгөрсөн 12-р сард Рио Тинто нь олон улсын сэтгүүлчдэд “*бид ямар нэгэн шалгалтын албан ёсны тайлангийн талаар юм мэдэхгүй*” гэж хэлж байсан. Энэ нь Рио Тинтогийн алдаа *өчүүхэн төдий ч нөлөө үзүүлээгүй* гэх нь *юун дээр ч үндэслээгүй* мэдэгдэл болно. Мадагаскарын ард түмэн ба өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу Рио Тинто нь өөрийн болон охин компаниудын хөрөнгө ба түүнээс даган гарах эрсдэлийн талаар тодорхой мэдээллийг өгч байх ёстой. Мөн түүнчлэн Рио Тинтогийн тунхагласнаар өөрийн үйл ажиллагаанд хамгийн өндөр стандартыг хэрэгжүүлэх ба орон нутгийнх нь эдгээр шаардлагыг хангаж чадахгүй тохиолдолд Рио Тинто олон улсын стандартад нийцүүлнэ гэдгээ мэдэгддэг. Рио Тинто нь Малагасийн зохицуулагч QMM уурхайн үйл ажиллагааг бодит үзүүлэлтээр хянах техникийн бололцоогүй гэдгийг мэднэ. Мөн түүнчлэн зохицуулагч нь QMM-ээс санхүүгийн хамааралтай болсон нь асуудал юм. Нутгийн иргэд уурхайг хянах болоцоогүй. Ийм учраас QMM хамгаалалтын бүсийн зөрчил, цацрагийн туяаны асуудал, усны чанарын талаар бие даасан судалгааг хүлээж авсан. Эдгээр судалгаагаар *уурхайгаас доош урсаж буй ус бохирдолтой байгаа нь хөдлөшгүй нотолгоотой* – уран, хар тугалганы агууламж нь ДЭМБ-аас аюулгүй ундны усанд тогтоосон түвшингээс дор хаяж 50 дахин өндөр байна. Бидний байгаль орчинд QMM-ийн үйл ажиллагаа “үл мэдэгдэх, өчүүхэн” нөлөөтэй гэж бид үзэхгүй байна.

Аноси тосгоны COVID 19-тэй тэмцэх ажилд туслах гэсэн QMM-ийн хувь нэмрийг бид талархан хүлээж авна - үүндээ хөрөнгө, сайн санааг олж чадсан уурхай нь байгалийн усны эх үүсвэрийг нь үйл ажиллагаагаараа бохирдуулж буй ард иргэдийг ундны цэвэр усаар яагаад хангахгүй байна? РТ нь өөрийн QMM уурхайгаас байгаль орчныг хүнд металаар огт бохирдуулаагүй, эргэн тойрон байгальд ба оршин сууж буй иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй гэх шинжлэх ухаанд тулгуурласан хатуу нотолгоог гаргаж өгөх үү? Хэрэв чадахгүй бол 1) хоосон үндэслэлгүй мэдэгдэл гаргахаас татгалзах уу? 2 / нутгийн иргэдийг ундны цэвэр усаар хангах уу? 3) бохир ус, уурхайн хаягдлын менежментээ яаралтай өөрчлөх үү?

2. Ивон Оренго, Andrew Lees Trust (ALT UK)

ALT UK-ийн бие даасан судалгааны зөвлөмжийн дагуу цацраг идэвхийн судалгааг шинээр эхлэж байгааг талархан хүлээн авч байна. Гэхдээ энэ нь өнгөрсөн жилээс хойш нэн яаралтай гэж тавьсан [усны бохирдлын асуудлыг](#) хөндөхгүй байна. 15,000 хүн уурхайгаас асгаж буй уран, хар тугалгаар бохирдсон орчны усны эх үүсвэрээс ундны усаа үргэлжлүүлэн авсаар байна.

Та өнгөрсөн жил ба сая дахин хэлэхдээ уул уурхайн ажиллагаа нь усыг зөвхөн ашигладаг, байгалийн орчинд юу ч өөрчлөгддөггүй гэлээ ... гэхдээ та олборлох үйлдвэрлэлийн явц нь уран, түүнчлэн хүнд

металлын гэх мэт радио-нуклидүүдийг уурхайн сав газарт төвлөрүүлдэг гэж бичгээр зөвшөөрсөн; иймд энэ асуудал нь уул уурхайн үйл ажиллагаатай шууд холбоотой ба ДЭМБ-ын ундны усны аюулгүйн хол давсан үзүүлэлт юм. Мөн QMM-ын үйл ажиллагаанаас гарч буй ус нь ундны усны стандартаар аюулгүй гэж үзэхээс илүү хэмжээний эрдэс бодис, металлын агууламжтай байж болзошгүйг та хүлээн зөвшөөрсөн. Үйл явцыг хянаж байгаа гэх ба бүх зүйл "сайн" байгаа гэх мэдэгдлүүдээс гадна нь танай бохир усны менежмент нь тунгаах цөөрмийн системийг ашиглан бохир усаа байгаль орчинд хаяхаас өмнө яаж бохирдлыг нь арилгадаг талаар ямар ч нотолгоог бидэнд ба өөр нийгмийн төлөөллийн байгууллагуудад гаргаж өгөөгүй л байна. Тэгдэг л гэж хоосон мэдэгддэг. Хэллээ гээд үнэн болдоггүй. Бид нотолгоог хүлээсээр байна. Рио Тинтод нотлох л үүрэг байгаа. Одоогоор нутгийн иргэд эдгээр бохирдсон нуур, гол мөрнөөс ус уусан хэвээр ба ДЭМБ-ын тавьдаг шаардлагын дагуу орон нутгийн иргэдийг аюулгүй ундны усаар хангах үүрэгтэй Рио Тинто нь тэгэхээс татгалзсаар л байна. РТ / QMM нь Мадагаскар дахь ундны усны зорилтот түвшинг хангахад хувь нэмэр оруулж чадна гэдгийг мэдэх ба бохирдуулагч төлбөр төлөх зарчмын дагуу үүнийг хийх ёстой. PWYPM -ийн Эрикээс тавьсан энэ асуултанд танайх хариулсангүй. Аносигийн иргэдийг ундны усаар хангаж, мөнгө хөрөнгөгүй Малагасийн засгийн газарт бохирдуулсан усыгаа цэвэрлэх ачааг үүрүүлэхээ болихыг хүсьеэ?

Рио Тинтогоос өгсөн хариултуудын тухайд

PWYP-аас тавьсан асуултууд:

Рио Тинто (РТ) нь QMM далангийн эвдрэлийн нөлөөг "өчүүхэн" гэж 2019 онд хувьцаа эзэмшигчиддээ тайлагнасан илтгэлд ямар ч үндэслэл баримт байхгүй гэсэн асуултанд хариулсангүй. Үүний оронд Гүйцэтгэх захирал нь хожуу 4 жилийн дараа даланг давсан тохиолдлуудын талаар ярьсаар дууссан.

- 1) РТ нь эвдрэлийн нөлөө *өчүүхэн* гэж нийтэд зарлаад байгааг нотлох ганц ч хамаагүй судалгааны тайлан(гууд) өгөх ба \буюу судалгаа хийгдээгүй гэж албан ёсоор мэдэгдэнэ үү?
- 2) Рио Тинто компанийн QMM уурхайн орчин тойронд буй усны бохирдол QMM-ын хаягдал устай холбоогүй гэдгийн эд баримтыг гаргаж өгнө?
- 3) РТ дараах гаргасан санал хүсэлтийг хүлээн зөвшөөрөх үү? а) үндэслэлгүй мэдэгдлүүд гаргааа зогсоох; б) нутгийн иргэдийг ундны цэвэр усаар хангах; в) бохир ус, уурхайн хаягдлын менежментийг яаралтай засах уу?

ALT UK-н асуултууд:

Ундны цэвэр усаар хангах асуудлуудын хариуд РТ олборлох үйл явцад химийн нэмэлт бодис хэрэглэдэггүй гэж зүтгэсээр ирсэн. Уран, хүнд металлын өндөржсэн түвшин нь химийн бодисоос бус харин уурхайд элсийг бутлах явцад баяжиж нягтардаг тухай Рио Тинто мэдэх ба ALT UK, Мадагаскар ба Нэгдсэн вант улсын PWYP, Friends of the Earth зэрэг байгууллагуудад илгээсэн захидалдаа үүнийг хүлээн зөвшөөрсөн болно. (2020 оны 2 сар)

- 4) QMM уурхайгаас гарч байгаа бохир ус нь зүгээр гэх QMM усны хяналтын баримтыг өгнө үү?
- 5) Рио Тинто нь Свонсон ба Эмерманы нарын усны судалгааны дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа гэдэгтээ (2020 оны 3-р сарын 6-ны өдөр Рио Тинтод илгээсэн хамтарсан захидалдаа дурдсан асуудлыг харгалзан үзэж¹) шинжлэх ухааны тайлбар өгнө үү.
- 6) Рио Тинто нь 2019 оны эцсээр² дээжийг нь авсан JBS & G усны судалгааны дүнг хэзээ танилцуулах боломжтой вэ?
- 7) РТ 2019 оны 3-р сараас хойш хүссэнийн дагуу ундны цэвэр усаар хангах асуудлыг хэзээ зөвшөөрөх вэ?

¹ ALT UK-н усны судалгааны талаар Рио Тинто ба Andrew Lees Trust, Publish What You pay MG ба UK, мөн Friends of the Earth хооронд хийгдсэн санал солилцоо.

² Гуравдугаар сард дүнг гаргааар амласан, дээжийг лабораторид 1 сар, их хоцроосон гэхэд 2-р сард, "түгжигдэхээс" өмнө хүргэсэн байх ёстой. Тэгээд шинжилгээ нь лабораторид буюу хаана ч хүний оролцоог нэг их шаардахгүй.



Асуултуудыг Оюу Толгойн уурхайд нэрвэгдэж буй Ханбогд сумын малчдыг төлөөлөн тавив.

БОННУ (байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ)

УИХ-ын 92 дугаар тогтоол: ОюуТолгойн асуудлаар УИХ-ын ажлын хэсгийн зөвлөмжийг үндэслэн Улсын Их Хурал 2019 оны арваннэгдүгээр сарын 21-ний өдөр 92 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/law/details/14771?lawid=14771> гаргав. Үүгээр Засгийн газарт Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ болон холбогдох бүх гэрээг хуульд нийцүүлэхээс гадна дараах ажлуудыг хийж гүйцэтгэхийг даалгав. Үүнд:

4/ Оюутолгойн ордын зэс, алт, мөнгө болон бусад элементийн нөөцийн үнэлгээг Монголд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын жишигт нийцүүлэн дахин үнэлэх, дахин үнэлгээнд үндэслэн шинээр ТЭЗҮ боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагын шинжээчийн дүгнэлтийг авах;

5/ Байгаль орчин, усны нөлөөллийн үнэлгээг дахин боловсруулж, говь цөлийн бүсэд газар доорх ус ашиглалтын шаардлагад нийцүүлэн Засгийн газрын нийтийн хэрэгцээний газрын эзэмшүүлэх тухай 2011 оны 6-р сарын 8-ны өдрийн 175 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах.

2017 MDT/IEP, р. 26/2289 - ОТ нь далд уурхайн төсөлтэй холбоотой аливаа нэмэлт сөрөг нөлөөллийг (мөн нөлөөллийг бууруулах арга хэмжээ) олж тогтоох, зөвлөлдөх зорилгоор ОУСК-ын стандартаар нэг буюу хэд хэдэн БОНБҮ-г ажил эхлэхээс өмнө гаргаж, нийтлэх ёстой; мөн эрчим хүчний гэрээ; ажиллах хүчний байрны төлөвлөлтийн өөрчлөлт; төмөр замын барилгын ажил; Ханбогд сумаас ОТ хүртэлх автозамын хатуу хучилт зэрэг 2012 оны БОНБҮГ нийтлэгдсэнээс хойш төсөлд гарсан аливаа мэдэгдэхүйц өөрчлөлт, бусад дэд бүтэц, уурхай /газрын тосны төслүүдийн хураангуй нөлөөллийн үнэлгээг шинэчлэх. Жишээ нь, сумын төвөөс ОТ хүртэл хатуу хучилттай хурдан замтай болгоход малын хөдөлгөөнийг хир хязгаарлах зэрэг үнэлгээ байх хэрэгтэй.

Асуулт нэг: Рио Тинто эдгээр зөвлөмжийн талаар юу хийж байгаа вэ?, мөн дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын, Олон талт баг (MDT) -ийн тайланд заасан зөвлөмжийн дагуу далд уурхайг барих явц ба ажиллагаанд оруулах үе, хаягдал хадгалах шинэ байгууламжийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хэзээ хийх вэ?

УС

Говь цөл дахь ус: Усны талаарх судалгааны тайлангуудын нууцлал, компанийн усны талаар олон нийтэд хийж буй мэдэгдлүүд нь Рио Тинто ба нутгийн малчдын хооронд олон жил үргэлжилсэн маргаан болоод удаж байна.

ОТ нь усны дахин боловсруулалтын хэмжээ дунджаар 85% хүртэл нэмэгдэж, зарим тохиолдолд 90% -иас дээш гарсан талаар 2018 оны жилийн үзүүлэлтүүддээ техникийн дэлгэрэнгүй мэдээлэлгүйгээр тунхаглаж байна [Хамгийн сүүлийн үеийн тайланг www.ot.mn сайтаас үзэх боломжтой р. 7/58 https://www.ot.mn/media/ot/content/docs/year_in_review_18/OT_Year_in_Review-English.pdf хаягаар).

Үүний эсрэгээр, ОТ-ийн үйл ажиллагаанд хийгдсэн цөөн тооны бие даасан тайлангийн нэг болох 2017 оны MDT/IEP тайлан (www.caoombudsman.org/cases/document-links/documents/MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf)-д ОТ-н зөвлөхүүд нь хаягдлын менежмент, устгах үйл ажиллагаа нь зураг төслөөс зөрж байгаа ба төлөвлөсөн хэмжээнээс илүү их услаг, хуурай хаягдлын агууламж бага – нийт овор нь их – тул төлөвлөсөн хугацаанаас өмнө шингэнлаг хаягдлыг хадгалах байгууламжийг дүүргэх төлөвтэй гэж дурдажээ. (2017 MD / IEP, P. 207/289). Үйл ажиллагааныхаа төлөвлөсөн төслийн гүйцэтгэлийг хангаж чадахгүйн дүнд ОТ нь 2012 оны БОННУ-д \Р. 34/77\ тодорхойлогдсон хаягдлын хоёр сангийн хүчин чадлыг хугацаанаас эрт дүүргэх болно.

Одоо ОТ нь хаягдал хадгалах байгууламжийн 1-р дүгээр хэсгийн хэмжээтэй буюу ойролцоогоор 750 сая тоннын багтаамжтай нэмэлт дөрвөн сан байгуулахаар төлөвлөж байна.

Уурхайн усны хэрэглээг нарийвчлан харуулсан ОТ нь усны менежментийн тооцоог дараах үзүүлэлтээр гаргаж өгөхийг бид шаардаж байна. Үүнд:

- Усны нийт баланс, түүний дотор 2012 оны БОННУ-ний \А4 at p. 41/77\ төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны элемент тус бүрийн усны хэрэглээний хувь хэмжээг;
- Шингэн болон хатуу хаягдлын балансыг үйл ажиллагааны явцад үүссэн хаягдлын масс, хэмжээ, усны агууламжийг тусгасан байдлаар ба хаягдал агуулах байгууламжуудын өнөөгийн байдлыг 2012 оны БОННУ-ний зураг төсөлд төлөвлөсөн байдалтай харьцуулсан байдлаар;
- Ирээдүйд санал болгож буй хаягдлын байгууламжийн нарийвчилсан зураг төслийг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ба хаягдлын ажиллагаанд гарч болзошгүй доголдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний хамт.

Асуулт хоёр: Рио Тинто компанийн хувьцаа эзэмшигчид болон нутгийн иргэдэд чухал ач холбогдолтой ийнхүү мэдээллийг нууцлаад байдаг үндэслэл юунд байна вэ?

ОНЛАЙН ХУРАЛДААНЫ ҮЕЭР АСУУХААР БЭЛТГЭГДСЭН АСУУЛТ:

Гурван талт зөвлөлийн хурлын явцад ОТ-ийн багийн ахлагч (Ш.Байгалмаа) ОТ нь ОТ-д барилгын болон бусад материалыг нийлүүлэх туслан гүйцэтгэгч компаниудаа хянах болоомжгүй (эсвэл алдагдсан) байна гэж мэдэгдэв. Туслан гүйцэтгэгч нар нь Ханбогд сумын бэлчээрийн газарт олон тооны карьеруудыг ашиглахдаа өөрийн ажиллагааны БОННУ хийгээгүй ба байгаль орчныг хамгаалах ажиллагааны төлөвлөгөөг мөрддөггүй байна. Нөлөөлөлд өртсөн малчдын үзэж байгаагаар Рио Тинто нь өөрийн хүлээсэн үүрэг, салбарын болон зээл олгогчдын хариуцлагын стандартыг дагаж, ханган нийлүүлэлтийн сүлжээгээ удирдахгүй байна гэсэн үг. Уурхайн 2-р үе шатны гүний уурхайн БОННУ-д өөрсдийн туслан гүйцэтгэгч компаниудын хүрээлэн буй орчинд, ялангуяа усны нөөц, бэлчээрт үзүүлэх нөлөөллийг тусгах төлөвлөгөө та нарт байна уу?



StichtingOnderzoekMultinationaleOndernemingen

Centre for Research on Multinational Corporations

Роданте Аалерс, SOMO: Монгол дахь Оюу Толгойн төсөлтэй холбоотой асуултууд:

1. Ковид-19 цар тахал нь хүний амь насыг хамгаалахад шаардлагатай бараа, үйлчилгээг авах гэж тэмцэж буй орнуудад улсын төсвийн ач холбогдлыг харуулсан өнөө үед Рио Тинто нь UNCITRAL-д эхлүүлсэн арбитрын ажиллагаагаа цуцалж, Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг Монголын ард түмний болон байгаль орчныг нь хамгаалах хэрэгцээнд нийцүүлэхээр эргэн харах уу?
2. Рио Тинто нь Монгол Улсын Парламентын 92-р тогтоол (2019 оны 11-р сар) болон олон талт багийн тайлан (2017 оны MDT/IEP, хуудас 26/2289)-д туссан зөвлөмжийн дагуу далд уурхайн бүтээн байгуулалт, ашиглалт, хаягдал хадгалах байгууламжийн хэсэг зэргэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хэзээ хийх вэ?
3. Ус бол говь цөл дахь амьдралыг тэтгэгч нөөц юм. Рио Тинто нь усны нийт баланс, үйл ажиллагаан элемент тус бүрийн усны хэрэглээний хувь хэмжээ, илүү хэмжээний хаягдлын сангийн хэрэгцээг үндэслэх хаягдлын шингэний шинж чанар, шинэ хадгалах сангийн зураг төсөл зэрэг устай холбоотой тайлан мэдээллийг олонтой шаардсан ч гаргаж өгөөгүй. Хэзээ энэхүү мэдээллийг, аль эсвэл мэдээллийг нууцлах үндэслэлийг албан бичгийн хэлбэрт оруулсан байдлаар хүлээн авч болох вэ?

Рио Тинто ба Бугэйнвиль дэх Panguna уурхайн хувь заяа: Human Rights Law Centre-ийн Керен Адамсын асуултууд

ЖЕХ-ын хэлэлцүүлэгт Мельбурн дахь Human Rights Law Centre-ийн ажилтан Керен Адамс нутгийн иргэдийг амьдрал, амьжиргаа, хүний эрхээр ноцтой хохироосон Бугэйнвиль дэх Panguna уурхайн байгаль орчин, нийгэм, соёл, оюун санааны сөрөг үр дагаврын талаар дараахь асуултыг тавьжээ.

2016 онд Рио Тинто Бугэйнвиль дэх Panguna уурхайгаас салж, тэнд үйл ажиллагааныхаа бараг нэг тэрбум тонн уурхайн хаягдлын хаягдлыг үлдээжээ. Үүний үр дүнд уурхайн эргэн тойронд хэдэн мянган хүний усны эх үүсвэр нь бохирдож, тосгон нь уурхайн бохирдлын үерт автаж, арьсны болон амьсгалын замын өвчинд нэрвэгдэж хүний эрхээр ноцтой эрсдэж байна. Эдгээр асуудлын цар хүрээ, хэмжээний талаар эдүүгээ мэдээлэл авснаар:

1. Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах талаар Бугэйнвиль дэх оролцогч талуудтай Рио Тинто компани яриа хэлэлцээнд ороход бэлэн үү?
2. Компани олон улсын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ дагаж, 2014 онд орхигдон зогссон уурхайн байгаль орчин, аюулгүй байдлын үнэлгээг эргэн санхүүжүүлэх санаачлага зэргээр хүнд байдлыг арилгахад туслах арга хэмжээ авах уу?

ЖЕХ-д өгсөн хариултандаа Рио Тинто компанийн ТУЗ-ийн дарга Саймон Томпсон аль ч асуултанд хариу өгсөнгүй.

Ноён Томпсоны хариулт нь 1960-аад оноос 1980-аад оны сүүл хүртэл Пангуна уурхайн түүхийн нилээд төөрөлдүүлсэн товч тойм өгснөөр болж, арал дээрх иргэний дайны улмаас уурхай үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатай болсон гэв. Дайны гол шалтгаан нь Пангуна уурхайгаас үүдсэн хүрээлэн буй орчны доройтол, нийгмийн задрал байсан тухай үг ч дугарсангүй. Рио Тинто компани нь Папуа Шинэ Гвинейн Засгийн газарт цэргийн ажиллагаагаар уурхайг эргүүлэн авахаар шахалт үзүүлсэн, мөн Папуа Шинэ Гвинейн зэвсэгт хүчинг өөрийн логистикаар дэмжсэн хоёр үйлдэл нь уурхайг тойрсон зөрчилдөөнийг урт удаан үргэлжилсэн иргэний мөргөлдөөнд шилжихэд нөлөөлснийг ноён Томпсон хүлээн зөвшөөрөөгүй.

Ноён Томпсон 1989 он хүртэл уурхайг хүчээр орхих хүртэл компани нь байгаль орчны хууль тогтоомж, стандартад бүрэн нийцсэн ажиллагаатай байсан, харин тэр цагаас хойш аюулгүй байдлын үүднээс тэр нутагт очих боломжгүй болсон гэх олон нийтэд ярьдаг стандарт зүйлийг давтсаар байв.

Бодит байдал дээр ОТ компани байгаль орчны бүхий л хууль тогтоомж, тухайн цаг үеийн стандартыг дагаж мөрдсөн гэж хэлж буй нь үнэнд нийцэхгүй. Пангуна уурхайн

үйл ажиллагааг зохицуулсан анхны гэрээнд (компани ба тухайн үеийн Австралийн колоничлолын захиргааны хооронд Бугэйнвиллийн газар өмчлөгчдийн илэрхийлсэн хүслийг үл харгалзан байгуулсан) хүрээлэн орчны хамгаалалтын заалтууд сул байсан боловч гэрээ нь байгаль орчинд байнгын хор хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, уурхайгаас голд асгасан бохирдол нь ургамал, амьтны амьдралд ноцтой хохирол учруулахгүй үйл ажиллагааг компаниас шаардсан байдаг. Гэрээ нь уурхайн үйл ажиллагаанд өртсөн газрыг нөхөн сэргээж, ашиглах боломжтой нөхцөл байдалтай газар эзэмшигчдэд буцааж өгөх арга хэмжээ авахыг компаниас мөн шаардана.

Эдгээр нөхцлийн альныг ч компани биелүүлээгүй. Үүний оронд нэг тэрбум тонн хаягдал хог хаягдлыг тоох ч үгүй Жаба, Каверонг голуудад асгаж, голын систем болон хүрээлэн газарт аль алинд нь нөсөр их байнгын хохирол учруулж, нутгийн иргэдийг тэтгэх урсгал дагуух усны амьдралыг бүхэлд нь устгасан.

Бугэйнвиль дэх аюулгүй байдал нь компанид үйл ажиллагааныхаа ул мөрийг цэвэрлэхэд саад болж байгаа гэдэг нь ч худал. Бугэйнвиль дэх мөргөлдөөн 1998 онд дуусан, уурхайг татан буулгахаас 18 жилийн өмнө ба энэ хугацаанд өөрөө буюу байгаль орчны бие даасан компаниар ч дамжуулан цэвэрлэгээний ажлыг эхлүүлэх боломжтой байсан. Үнэн хэрэгтээ 2014 онд Бугэйнвиллийн газар эзэмшигчид ба автономит Бугэйнвиллийн засгийн газраас яг чингэхийг хүссэний хариуд уурхайг хаах шийдвэрийг гаргасан явдал юм.

Хэдийгээр Рио Тинтогийн Бугэйнвильд үлдээсэн ул мөрөө тухайн үед нь яагаад арилгаагүйн шалтагыг ойлгох хүн олдох боловч харин одоо үүнийгээ яагаад хийхгүй байгааг ойлгохгүй л байх. Рио Тинто нь НҮБ-ын Бизнес, хүний эрхийн мөрдөх зарчмууд, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Олон улсын аж ахуйн нэгжүүдийн Удирдамжийн аль алинд заасны дагуу үйл ажиллагаанд нь өртсөн хүмүүсийн хүний эрхийг хүндэтгэх, үйл ажиллагаа нь үүсгэсэн буюу хувь нэмэр оруулсан хүний эрхийн сөрөг нөлөөллийг арилгах үүрэгтэй. Байгаль орчин, хүний эрхийн асуудлаар дэлхийд тэргүүлэгч, хамтран ажиллаж буй нийгэмлэгүүдийн аюулгүй байдлыг нэгдүгээрт тавьдаг гэж өөрийгөө өргөмжлөдөг компанийн хувьд Рио Тинто нь Пангуна уурхайн орчимд амьдардаг олон мянган хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчны үргэлжилсээр байгаа хөнөөлт нөлөөллийг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ёстой.



Их Британид бүртгэгдсэн Earth Thrive ТББ-ын Зоу Лүжичээс Рио Тинтогийн ЖЕХ-д бичгээр өгсөн асуултууд. Асуултуудыг Сербийн Jadar литийн уурхайд нэрвэгдсэн Лозница хотын иргэдийн өмнөөс ирүүлсэн болно.

A1: Судалгаа болон бусад баримт бичгийг зөвхөн сонгосон бүлэг хүмүүстэй хуваалцаж байна гэсэн шүүмжлэлийн дагуу танай Сербийн охин компани болох Белград дахь Rio Sava Exploration Ltd-ын өнөөг хүртэл хийсэн БҮХ баримт бичиг, төлөвлөгөө, судалгааг шуурхай, бүрэн, нээлттэй байдлаар нийтэлж байхыг олон нийтээс хүсч байна.

Бүх бэлэн болсон баримтуудыг нэн даруй, бүрэн нээлттэй болгохдоо "энгийн хүмүүст" ойлгомжтой байдлаар ил тод, нийтэд нээлттэй байдлаар хийнэ гэсэн баталгаа өгнө уу?

A2: Танай ашиглахаар төлөвлөж буй бараг 300 хавтгай дөрвөлжин км хамарсан талбайд 4 буюу илүү тооны хамгаалалттай бүс бий.

Тусгай хамгаалалттай газар нутаг нь танай уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас учирч болзошгүй хор хөнөөлөөс жинхэнээр, бүрэн хамгаалагдана гэсэн ил, нээлттэй чанд баталгааг гаргаж чадах уу?

Түүнчлэн өөрийн тохиолдолд холбогдох үндэсний болон байгаль орчны хууль тогтоомжийг бүрэн дагаж мөрдөх болно гэсэн бүрэн амлалтыг өгч чадах уу?

A3: **Эргэн тойрон хөдөө аж ахуйн газар нутаг нь танай уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртөхгүй гэсэн нээлттэй, чанд баталгааг гаргаж чадах уу?**

A4: Хоёр жилийн өмнө нутгийн иргэдэд санал болгож буй уурхайн бүрэн хэмжээний 3D загварыг амласан бөгөөд тэр нь одоог хүртэл хэрэгжээгүй гэх ойлголт бидэнд байна. **Энэ загварыг хэзээ гаргаж өгөх, мөн хэзээ нутгийн болон өргөн олонд яг ямар төрлийн уурхайн арга ашиглагдах талаар тодорхой мэдээлэл өгөх тухай мэдэгдэж өгнө үү?**

Рио Тинтогийн ЖЕХ-ны дараах хувьцаа эзэмшигчдийн оролцоот телеконференцийн үеэр Гүйцэтгэх захирал ЖС хэлэхдээ уг төсөл нь эхний шатандаа явж байгаа бөгөөд уурхайн цар хүрээг тодорхойлж байна гэв. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ 2020 онд COVID-19 холбоотогоор хүлээгдэж байна. Бид бүх оролцогч талуудтай хамтарч ажиллах ёстой бөгөөд цаашид олон нийт, ТББ-уудтай үргэлжлүүлэн холбогдох болно гэж тэр хэллээ. Судалгааны талаар мэдээлэл хуваалцах тухайд болон орон нутгийн хууль тогтоол, протоколыг дагаж мөрдөх нь компани нь олон нийтэд нээж тавихаасаа өмнө судалгаагаа дуусгах ёстой гэсэн үг юм. Бид бүх үйл явцын турш зөвлөлдөхийг хичээдэг гэж тэр хэллээ. Тэрбээр орон нутгийн иргэдэд мэдээллийг илүү хүртээмжтэй болгох үүднээс хоёр мэдээллийн төв байгуулсан гэж хэллээ. Тэрээр хэлэхдээ 2019 онд тус компани өргөнөөр зарлаг түгээж 16 гаруй нээлттэй өдөр зохион байгууллаа. Мэргэжилтнүүдийг бэлэн байлгаж судалгааг хуваалцаж, ярилцаж ирэв гэжээ. Уулзалтуудыг серби хэлээр явуулж, тэдгээрт "энгийн" хүмүүс оролцож байв гэв.

Телеконференцийн дууны чанараас болж ЖС-ны хариултын бусад бүх нарийн ширийн зүйлийг сонсоход үнэхээр төвөгтэй байв. Түүний хэлсэн зүйлүүдийн нэг нь тус компани байгаль орчны тухай үндэсний бүх хууль тогтоомж, Европын холбооны зааврыг хүндэтгэх болно гэжээ. Тусгай төлөвлөгөө нь засгийн газрын баримт бичиг бөгөөд 290 хавтгай дөрвөлжин км талбай бүхий концессыг бүхэлд нь хамарсан байна. Энэхүү төсөл нь концессийн хүрээндэх дөрвөн хамгаалалттай бүсэд ямар ч сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хөдөө аж ахуйн зориулалттай газар нутгийн тухайд байгаль орчны стратегийн үнэлгээг баталж, бүх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлсэн, онлайнаар мэдээллийг авах боломжтой. Санал болгож буй уурхайн гурван хэмжээст загварыг 2016 онд орон нутгийн мэдээллийн төвүүдийн нэгд нь, 2018 онд нөгөөхөд нь байрлуулсан.

Уурхайн гурван хэмжээст загварын тухай ЖС ярьсан ч, Зоү Лүжич 2018 оны 5-р сард орон нутагт ажиллах үеэр хүмүүс энэ загварыг гаргаж өгөхийг байнга хүсч байсан ба тэд уурхай ямар байх, хэрхэн харагдах, мөн тухайн бүс нутагт хэрхэн нөлөөлөх тухай мэдэхийг ихэд хүсч байж. Уг асуудлаар идэвхтэй ажилладаг бусад орон нутгийн төлөөлөгчид загварыг хэзээ ч харж байгаагүй, олон нийтэд үзүүлсэн тухай мэдээлэл авч байгаагүй гэжээ.

Рио Тинто нь 3D-ийн уурхайн хамгийн сүүлийн үеийн хувилбарыг дагалдах барилга байгууламжтай (боловсруулах үйлдвэр гэх мэт) нь бүх тайлбар, өгөгдлийг энгийн хэлээр тодорхой бичсэн таниулагтай нь Лозница хотын захиргааны барилга буюу орон нутгийн мэдээллийн орон зай (олон нийттэй ярилцсан гэж мэдэгдэж байсан тэр газар) эсвэл үүнтэй төстэй өөр газар гаргаж олон нийтийн хүртээл болгох боломжгүй юм болов уу?



London Mining Network-ийн Андре Хикманы асуулт: Баруун Папуагийн Grasberg зэс, алтны уурхайн тухай.

Асуулт нь хог хаягдлын асуудал болон Рио Тинтогийн Бугэйнвильд үлдээсэн ул мөрийн тухай асуултуудын дараа тавигдав. Эндрю хэлэхдээ: "Та нар хоёр жилийн өмнө Grasberg-ээс салсан." "Grasberg-ийн хүрээлэн буй орчин, нийгэм, хүний эрхийн зөрчлийн ул мөр, түүнчлэн амь нас бохирдуулж устгадаг хог хаягдлыг голруу зайлуулах системийн талаархи баримтууд байхад компанийнхаа нэр хүндийг уурхайг Иналум гэгч Индонезийн хөнгөн цагаан үйлдвэрлэх төрийн компанид зарснаар хамгаалж яаж чадна вэ? Иймэрхүү хууль эрх зүйч байр суурийг баримтлах нь дээр дурдсан ул мөрийн баримтыг нүүрлэж байгаа компани болон түүний хөрөнгө оруулагчдад нэр хүнд, хуулийн ба санхүүгийн эрсдэл дагуулна?" гэжээ. Энэ бол ёс зүй ба ёс суртахууны асуудал юм. Эндрю хэлэхдээ компани нь хэдэн жилийн өмнө Пангуна дахь оролцоогоо орхисон гэх боловч тэнд байгаа хариуцлагын талаархи асуултанд хариулсаар байж яагаад Grasberg-д хариуцлага хүлээхээ больсон гэж ойлгож байна?

Саймон Томпсон хариуд нь "Та өнгөрсөн жил ЖЕХ дээр энэ асуудлыг тавьсан, миний хариулт өнөөдөр мөн ижил. Рио Тинто нь хөрөнгө оруулалтын гэрээ биш төмөр туузны гэрээнд оролцсон байжээ. Энэ уурхайгаас 1999 оноос хойш олборлосон металлын хувийг эзэмшиж байсан бөгөөд 2018 онд Индонезийн төрийн өмчит уул уурхайн компани болох Иналумд 3.5 тэрбум ам.доллараар түүнийгээ зарсан нь Индонезийн засгийн газраас стратегийн гэх үндэсний эдийн засгийн сонирхлын зорилтыг биелүүлэхэд нь дөхөм болсон юм. Индонезийн засгийн газар үүргүүдийн талаар мэдэж байсан бөгөөд төлсөн үнэ нь тэдгээр үүргийн талаархи мэдлэгийг илтгэнэ. Бид нуугдаагүй. Худалдаж авах хүсэлтэй худалдан авагч, хүсэлтэй худалдагч, Индонезийн засгийн газар эдгээр үүрэг хариуцлагыг хүлээх болно гэдгээ мэдээд үүнд оролцов" гэжээ.

Хэдхэн цөөн баримтын ард нуугдсан даргын өгсөн хариунд энэ асуултаар дэвшүүлсэн хоёр гол асуудалд хариулахаас зайлсхийв. Компанийн хувьд эрсдэлийн асуудал мөн Рио Тинтогийн Grasberg-д үлдээсэн ул мөрийн ёс зүйн хариуцлагын асуудал.

Асуултыг өнгөрсөн жил асуусантай ижил гэж үзэх нь буруу байв: Хариулт нь өнгөрсөн жилийнхтэй ижил байв. Өнгөрсөн жил Рио Тинто Grasberg дахь өөрийн сонирхлоо зарж борлуулах ажлыг дөнгөж хийж дуусаад, уурхайд хөрөнгө оруулах компанийн шийдвэр нь зөв байж уу, өөрөөр хэлбэл, хир хэмжээний мөнгийг үргэлжлүүлэн харийуцах ёстой байсан үүргүүдэд хуримтлуулсан бэ? гэх асуултанд хариулж байсан үе. Саймон Томпсоны хариулт нь хог хаягдлаа голруу хаядаг уурхайд хөрөнгө оруулсанд харамсах аястай эхэлснээ, дараа нь 2018 оны арилжаанд тулгарсан эрх зүйн нарийнруу ороод үргэлжлээ олсон. Хариуцлагын тухайд "нуух" гэдэг үгийг дарга өөрөө хэлснээр 2018 онд болсон явдлын бодит байдлын талаар хүссэнээсээ илүүг илчилсэн нь шогтой юм шиг.

Компанид учирч болох эрсдлийн тухайд эдгээр эрсдлийг гурван чиглэлээр авч үзэх нь тодорхой юм. Рио Тинтогийн нэр хүндийн эрсдэл нь тодорхой, иргэний нийгмийн уурхайн шүүмжлэгчид төдийгүй олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тайлбарлагчид, том нөлөө бүхий Норвегийн Төрийн Тэтгэврийн сан зэрэг институцийн хөрөнгө оруулагчдын нүдэнд жигшүүрт уул уурхайн үйл ажиллагаатай жагсаалтыг тогтмол тэргүүлж буй уурхайг огтлох, зугтах маягаар борлуулсан явдал мөн. Рио Тинто компанид үзүүлэх хууль эрхзүйн болон санхүүгийн эрсдэл нь тийм тод биш ч хөрөнгө оруулагчид болон компани нь өөрөө санаа зовбол зохино. Одоогийн байдлаар Рио Тинтогийн Grasberg-д орхисон хариуцлагыг шүүхээр нэхэмжлээгүй, гэхдээ энэ уурхайн учруулсан хохирол илт байгаа. Бизнесийн хоёр тал тохиролцоонд хүрснээр хариуцлага зогсоно гэх ойлголт нь тийм ч зөв дүгнэлт биш гэдэг олон тохиолдол сүүлийн жилүүдэд гарч байна.

Рио Тинто өөрийгөө хариуцлагатай корпорацийн иргэн, дэлхийн уул уурхайн салбарын манлайлагч, энэ гаригт илүү сайн ирээдүйг авчрах сайн үйлсийн хүч гэж өөрийгөө танилцуулдаг байна. Компани нь өөрийгөө "хүний хөгжил дэвшилд чухал үүрэг гүйцэтгэдэг" гэж үздэг бөгөөд "бид үүнд бүгд хамтдаа" гэж ярьж сурталчилдаг. Хэрэв үнэн бол яагаад компанийн дарга нь Grasberg-д үлдээсэн хог, хөнөөлт уршгаас огтлох, зугтах арилжаагаар зайлахын ёс зүйг асуусан шулуун асуултанд хариулж чадахгүй байна? Компанийн хариуцлагаас зугтах байдлаар хууль эрх зүй, санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлд орох асуудлыг орхиод тавьсан ёс зүйн асуултанд хариулт өгөх нь даргын шууд үүрэг байх ёстой. Рио Тинто мэт нэр хүнд бүхий компани нь өөрийн үйлдлийн ёс суртахууны хариуцлага нь нэг чек, цаасан дээрх хууль эрх зүйн заалтаар зогсохгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй?